



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 8/98.

Улаанбаатар хот

Г  
Зочид буудал, дэн буудал, амралтын газрын  
үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтооолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан гурван аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан нэг аж ахуйн нэгжид дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Жи Би Эс Импекс ХХК-ийн "Хабу" зочид буудлын 14/54, АББЦ ХХК-ийн "Лайк" зочид буудлын 15/100, Мөнх-Алкес ХХК-ийн "Вива Юс" дэн буудлын 15/036 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /С.Туул/-д үүрэг болгосугай.

5. Зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг нягтлан бодогч /Г.Цэрэннадмид/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *D.Batsoy* Д.БАТСҮХ



1150500273

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2016 оны 11 сарын 14 өдрийн  
A/98 дугаар тушаалын нэгдүгээр  
хавсралт

УОА0463

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2016.11.14

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистраийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Жи Би Эс Импекс ХХК	2767864	Хабу	Баянгол дүүрэг, 1-р хороо, Замчдын 48а
2	АББЦ ХХК	5818656	Лайк	Баянзүрх дүүрэг, 6-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 31/13
3	Дэлгэрэх Цадиг ХХК	5364671	Фанат	Баянгол дүүрэг, 16-р хороо, Амарсанаагийн гудамж 48

-ооОо-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2016 оны 11 сарын 14 өдрийн  
A/98 дугаар тушаалын хоёрдугаар  
хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2016.11.14

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Мөнх-Алкес ХХК	5082919	Вива Юс	Баянзүрх дүүрэг, 2-р хороо, Их Дарь эхийн 1/44

-ооОоо-